



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН АЛБАН ДААЛГАВАР

2014 оны 05 сарын 21 өдөр

Дугаар 02

Өлгий

Мал амьтны халдварт өвчинтэй тэмцэх  
ажлыг эрчимжүүлэх тухай

Тус аймагт сүүлийн жилүүдэд мал, амьтны шүлхий, галзуу, паразит зэрэг халдварт өвчний гаралт, тархалт нэмэгдэж, мал аж ахуйн үйлдвэрлэлд сөрөг нөлөө үзүүлж багагүй хохирол учруулж байгаа ба он гарсаар 4 суманд үхрийн галзуу өвчин 2, галзуу өвчтэй чоно, үнэг 2, нийт 4 тохиодол гарлаа. Энэ нь хүн, малын шилжилт хөдөлгөөн нэмэгдэх, зарим малчид, бизнес эрхлэгчид малын тоо толгойг өсгөх, чанаржуулах нэрээр өвчний голомт бүхий гадны аймаг, сумын нутгаас мал олноор авчрах, малчид өвчтэй малаа нядалж, хүнсэнд болон зах зээлд борлуулах, хүнсний зүйлийг ил зарах, түүхий эдийг хотын төвд ил задгай газарт цуглуулж ус, хөрсний бохирдол хог үүсгэх, мал эмнэлгийн мэргэжлийн болон хяналтын байгууллагуудаас тавих хяналт сул, уг халдварт өвчинтэй тэмцэх зааврыг малчид, иргэд мөрдөж ажиллахгүй байгаа нь цаашид нийгмийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлийг бий болгож байна.

Иймд мал, амьтны халдварт өвчний гаралт, тархалтыг тогтвортой бууруулах, өвчин тархах, дамжин халдварлах бүх замыг таслан зогсооход мэргэжлийн байгууллагууд, сум багийн удирдлага, малчид, мал бүхий иргэдийн анхаарлыг чиглүүлэн ажиллах зорилгоор Монгол улсын Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 45.4, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "а", 29.1.6-гийн "л", 29.2 дахь заалтыг үндэслэн ДААЛГАХ нь:

Нэг. Сум, багийн Засаг дарга нарт:

1.1. Мал, амьтны халдварт өвчин гарсан тохиолдолд уг өвчинтэй тэмцэх зааврын дагуу хорио, хязгаарлалт тогтоож, цаашид өвчин тархахгүй байх удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авах

1.2. Төв суурин газар, нийтийн хэрэгцээнд нийлүүлэхээр бэлтгэгдсэн мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд хийгдэх үзлэг, шинжилгээг харьяа мал эмнэлэг, үржлийн нэгжүүдээр хийлгэн гарал үүсэл, чанарыг тодорхойлуулж гэрчилгээ олгуулах, мал эмнэлэг, үржлийн тасгийн малын эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн, байцаагч, багийн Засаг даргаар баталгаажуулж, мал эмнэлэг, ариун цэврийн гарал үүслийн гэрчилгээ, түүнийг хэрэглэх журмыг мөрдүүлж ажиллах, ард иргэдэд энэ чиглэлийн сургалт, сурталчилгааг тогтмол хийж хэвшүүлэх

1.3. Сургууль, цэцэрлэгийн хүнсэнд хэрэглэж буй махан бүтээгдэхүүнийг тогтмол шинжилгээнд хамруулж, нийлүүлэлтэнд хяналт тавьж байх

1.4. Малчид, иргэдэд сэрэмжлүүлэг, мэдээллийг хүргэх, өвчтэй малын сэг, зэмийг устгах ажилд багийн Засаг дарга, сумын Гамшгаас хамгаалах штабын бүрэлдэхүүнийг үүрэгжүүлж оролцуулах

1.5. МЭҮТ сумын хэмжээнд мал эрүүлжүүлэх арга хэмжээнд хяналт, шалгалт хийж, дүнг тухайн шатны Засаг даргын зөвлөлд танилцуулах, ажлын үр дүнтэй нь холбож үйлчилгээний хөлсийг нэгжүүдэд олгох ажлыг зохион байгуулах

1.6. Өлгий сумын удирдлагууд хүнсний ногоо, сүү цагаан идээ худалдаалах тэр тусмаа намрын улиралд төмс, хүнсний ногоо худалдаалах явдал ихэсдэг байдлыг тооцож зориулалтын орон байраар хангах арга хэмжээг зохион байгуулах

### **Хоёр. Аймгийн Үйлдвэр, хөдөө аж ахуйн газарт**

2.1. Аймгийн хэмжээнд ажиллаж байгаа мал эмнэлгийн үйлчилгээний бүх нэгжүүдийг аттестатчлах ажлыг зохион байгуулж, Мал эмнэлэг үржлийн тасаг, Мал эмнэлэг үржлийн үйлчилгээний нэгжийн мэргэжилтнүүдийн мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх ажлыг тогтмол зохион байгуулах

2.2. Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний эм, биобэлдмэлийг хугацаанд нь татан авч мал эмнэлэг, үржлийн тасгуудад нийлүүлж, хэрэглээнд нь хяналт тавьж ажиллах

2.3. Сумдын мал эмнэлэг, үржлийн үйлчилгээний нэгжүүдэд шаардагдах мал эмнэлэг ариун цэврийн гарал үүслийн гэрчилгээ, төлбөрийн хуудсыг холбогдох газарт захиалах, татан авч хуваарилж олгох, мал эмнэлэг үржлийн тасаг, нэгжийн эмч мэргэжилтнүүдийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах

2.4. Малчид, олон нийтэд урьдчилан сэргийлэх, сэрэмжлүүлэг, мэдээллийг тухай бүр өгч хэвлэл, мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах

### **Гурав. Аймгийн Мэргэжлийн хяналтын газарт:**

3.1. Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний явц, биелэлт, ажлын чанарт тавих хяналтыг тогтмолжуулах

3.2. Тухайн сум, багт халдварт өвчин гарсан тохиолдолд авах арга хэмжээг шуурхай зохион байгуулж, шалтгааныг тогтоож, гэм буруутай этгээдэд хариуцлага тооцох

3.3. Хүнсний захын лабораторт мэргэжлийн шаардлага хангасан малын их эмч ажиллуулах, дулааны улиралд ажиллах цагийн хуваарьт нь өөрчлөлт хийх, зах дээр зарагдаж буй мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд хийгдэх үзлэг шинжилгээг холбогдох журмын дагуу чанартай, шуурхай хийлгэх, үйл ажиллагаанд нь тогтмол хяналт тавьж ажиллах

3.4. Мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн бэлтгэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, худалдах явцад мал эмнэлэг, ариун цэвэр, эрүүл ахуйн үзлэг, шинжилгээ хийлгэсэн эсэхэд шалгалт хийх

3.5. Хүний эрүүл мэндэд хор учруулах, малын өвчин тараах нь тогтоогдсон малын гаралтай түүхий эд, хүнсний бүтээгдэхүүнийг нийтийн хэрэгцээнд нийлүүлэх, эдгээр зүйлээр үйлдвэрлэл, үйлчилгээ явуулахыг таслан зогсоох, шаардлагатай үед хурааж устгуулах буюу халдваргүйжүүлэх арга хэмжээ авахуулах, хүнсний захад тавигдах хяналт шалгалтыг сайжруулах

3.6. Суурь өрх, баг, сум, аймгийн хооронд хийгдэх малын шилжилт хөдөлгөөнд тавих хяналтыг эрс сайжруулж, малын халдварт, паразиттах өвчин дамжин халдварлахаас сэргийлж, хорио цээр, хязгаарлалтын дэглэмд тавих хяналтыг бүх шатанд хэрэгжүүлж, гарсан зөрчил дутагдлыг шуурхай арилгуулж байх

3.7. "Тирлик" захын ойр орчимд үйл ажиллагаа явуулж байгаа ил задгай хүнсний болон сүү, цагаан идээний худалдаалалтанд тавих хяналтыг чангатгаж үйл ажиллагааг нь зогсоох арга хэмжээ авч ажиллах

3.8. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдэд "Хүнсний аюулгүй байдлыг хангах" сэдэвт сургалт зохион байгуулах, ард иргэдийг соён гэгээрүүлэх арга хэмжээ зохион байгуулах

**Дөрөв. Аймаг, сумын мал эмнэлэг, үржлийн тасаг,  
үйлчилгээний нэгжүүдэд:**

4.1. Үйлчилгээний нэгж бүр өөрийн хариуцсан багийнхаа мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөлтийг тухайн нутгийн өвчний голомт, судалгааг үндэслэн өрх нэг бүрээр нарийвчлан гаргаж мал эмнэлэг, үржлийн тасагтай хамтран ажиллаж, мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр өгөөжийг дээшлүүлэх

4.2. Мал, амьтны халдварт, паразиттах өвчин гарсан тохиолдолд авах арга хэмжээг уг өвчинтэй тэмцэх зааврын дагуу хугацаа алдалгүй авч хэрэгжүүлэх

4.3. Малын халдварт паразиттах өвчин өөр аймаг, сумаас дамжин орж ирэхээс сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж малчид, мал бүхий иргэд, бизнес эрхлэгч нарт мал эрүүлжүүлэхийн ач холбогдол мал, амьтны өвчний талаар сургалт, сурталчилгаа хийх, мэргэжлийн зөвлөгөө өгөх ажлыг тогтмолжуулах

4.4. Мал, амьтны халдварт, паразиттах өвчин гарсан газар, бууц буудлыг тухай бүр нь ариутган халдваргүйжүүлэх арга хэмжээ авах

4.5. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн орон нутгаас бэлтгэсэн мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг төв суурин газар оруулж худалдаалах, тээвэрлэхэд хийгдэх мал эмнэлэг, ариун цэврийн үзлэг, шинжилгээ, гарал үүслийг тодорхойлох, халдваргүйжүүлэх, гэрчилгээ олгох, баталгаажуулах ажлыг зохих журмын дагуу гүйцэтгэж, шуурхай үйлчлэх, ард иргэдийг мэдээллээр ханган сурталчлах

4.6. Сум орон нутгаас тээвэрлэгдэж байгаа мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг тухайн сум, орон нутгийн мал эмнэлгийн үзлэг шинжилгээнд хамруулах, мал эмнэлэг, ариун цэвэр, гарал үүслийн гэрчилгээтэй тээвэрлэх ажлыг сум орон нутгийн улсын байцаагч нарт үүрэг чиглэл өгч, хэрэгжилтийг хянан ажиллах

**Тав.Цагдаагийн газарт**

5.1. Малын хулгай, хулгайн түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүслийн гэрчилгээгүйгээр нийтийн хэрэгцээнд нийлүүлэх явдлыг илрүүлэх, таслан зогсоох, тээвэрлэлтийн явцад байнга хяналт, шалгалт хийх ажлыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж, мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах

5.2. Өвчтэй болон эрүүл ахуйн шаардлага хангаагүй мал, махан бүтээгдэхүүн худалдсан, нуун дарагдуулсан буруутай хүнийг олж тогтоон холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцож, ард иргэдэд мэдээлж ажиллах

5.3. Мэргэжлийн хяналтын газар, Өлгий сумын Тамгын газартай хамтран нэг сарын хугацаанд эргүүл, хяналт-шалгалтын ажлыг зохион байгуулж ажиллах

**Зургаа. Онцгой байдлын хэлтэст**

6.1. Малын халдварт галзуу өвчин тохиолдсон үед аймгийн Гамшгаас хамгаалах албадыг нэгдсэн удирдлагаар хангаж, шаардлагатай тохиолдолд нэмэлт хүч хэрэгслийг дайчлан гаргах ажлыг зохион байгуулах

6.2. Хүн, малын хөдөлгөөнийг хорих, сумын Засаг даргын захирамж гаргуулах, мэргэжлийн ангийн хүч хэрэгслийг хуваарилах, эргүүл пост гаргах, өвчилсөн малын тоог нарийвчлан гаргах, байнгын хяналт тавьж ажиллах

6.3. Хүн, малын гоц халдварт өвчний тухай нөхцөл байдлыг хүн амд зарлан мэдээлэх

6.4. Халдварт хамгаалалтын дэглэм, журам сахих ажилд мэргэжлийн байгууллагаар хяналт тавиулах

6.5. Үүссэн нөхцөл байдлын талаар мэргэжлийн байгууллагаас тогтмол мэдээлэл авч, аймгийн Засаг дарга, Онцгой байдлын комиссын даргыг мэдээ мэдээллээр хангах, шаардлагатай тохиолдолд удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авах

**Долоо. Дараах арга хэмжээ авч ажиллахыг холбогдох албан тушаалтанд:**

7.1. Малчид, мал бүхий иргэдэд дараах байдлаар орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон биечлэн очиж мэдээлэхийг сум, багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай. Үүнд:

-Халдварт галзуу өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд малаа цаг хугацаанд нь бүрэн хамруулах

-Өвчин гарсан тохиолдолд мал эмнэлгийн байгууллагад яаралтай мэдэгдэж, холбогдох арга хэмжээг авахуулах

-Малчид малынхаа хашаа хороог цэвэрлэх, засварлах, өтөг бууцаа задлан овоолж, биотермийн болон химийн аргаар ариутган халдваргүйжүүлэх ажлыг тогтмол хийж байх

-Малын үүлдэр угсааг сайжруулах зорилгоор гадны аймаг сум, баг, сууриас мал худалдан авахдаа мал эмнэлгийнхорио цээрийн дэглэмийг баримталж, үзлэг, шинжилгээнд заавал оруулж байх

-Малын гоц халдварт өвчний голомттой аймгуудаас мал авах, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн бэлтгэн борлуулах, тээвэрлэх, тууварлахдаа харьяа мал эмнэлэг, үржлийн үйлчилгээний нэгжүүдээр үзлэг шинжилгээ хийлгүүлж, гэрчилгээ авч, баталгаажуулах, тээвэрлэлт, тууварлалт борлуулах явцдаа холбогдох хяналт, шалгалтын байгууллагуудад шалгуулж гэрчилгээндээ тэмдэглэл хийлгэх, мал эмнэлэг, ариун цэвэр,эрүүл ахуйн шаардлагыг зөрчихгүй байх


- Өвчтэй малыг нядалж, хүнсэнд хэрэглэх, зах зээлд борлуулахгүй байх

-Төв суурин газар, нийтийн хэрэгцээнд нийлүүлэхээр бэлтгэгдсэн мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд хийгдэх мал эмнэлэг, ариун цэврийн үзлэг, шинжилгээг харьяа мал эмнэлэг, үржлийн нэгжүүдээр хийлгэн гарал үүсэл, чанарыг тодорхойлуулсан гэрчилгээг заавал авч байх

7.2. Энэхүү албан даалгаврыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж үр дүнг сар бүрийн 5-ны дотор аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтэст тайлагнаж байхыг Мэргэжлийн хяналтын газар /Х.Мерейхан/, Үйлдвэр, хөдөө аж ахуйн газар /Ж.Онгар/, Цагдаагийн газар /М.Батболд/, Онцгой байдлын хэлтэс /Б.Энхжаргал/, сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

7.3. Албан даалгаврын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар /Т.Манкей/-т үүрэг болгосугай.

ДАРГА



Х.ДАРМЕН